



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 07/2

Баян-Овоо


Ашиглалтын хугацаа дууссан үндсэн
хөрөнгийг данснаас хасаж актлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах шилжүүлэх журам", 2022 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 5.11 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Орон Нутгийн Өмчийн Газрын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 152 тоот албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу 3 нэр төрлийн 5 ширхэг 11.394.800 (Арван нэгэн сая гурван зуун ерэн дөрвөн мянга найман зуун) төгрөгийн балансын үнэтэй, үлдэх өртөггүй болсон хөрөнгийг данснаас хасч актлахыг нягтлан бодогч (С.Нандинцэцэг)-т үүрэг болгосугай.

2. Үндсэн хөрөнгийн бүртгэлд хяналт тавьж, холбогдох тайлан мэдээг танилцуулахыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Д.Агаармандал)-д даалгасугай.

ДАРГА



Д.ГЭРЭЛМАА

020000056